



ХУУЛЬЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН ЖУРАМ

**Улаанбаатар хот
2013 он**

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 11 дүгээр
сарын 2-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7, 48.10, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.6 дугаар зүйлийн 4, 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус удирдлага болгон Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 8.16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн “Монголын Хуульчдын холбооны сайн дурын хороодын зохион байгуулалттай холбоотой нийтлэг журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн “Монголын Хуульчдын холбооны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тухай журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 48 дугаар зүйлийн 48.9.3, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.13 дугаар зүйлийн 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн “Хуульчийн тангараг өргөх ёслолын журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тогтоолыг 2013 оны 11 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ

Д.БАТСҮХ

ХУУЛЬЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 дүгээр зүйл.Журмаар зохицуулах харилцаа

1.Энэ журмаар Монголын Хуульчдын холбоо /цаашид “Холбоо” гэх/-оос хуульчийн тангараг өргөх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

[/Энэ зүйлийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

1.2 дугаар зүйл.Тангараг өргөх үүрэг

1.Хуульч нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор Холбооны Тамгын газраас товлон тогтоосон өдөр, цагт Хуульчийн тангараг /цаашид “Тангараг” гэх/-ийг өргөнө.

[/Энэ зүйлийн нэрийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТАНГАРАГ ӨРГӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 дүгээр зүйл.Тангараг өргөх ёслолын ажиллагааны төв тогтоох

1.Холбооны Тамгын газар тангараг өргөх ёслолын ажиллагаа явагдахаас 14 хоногийн өмнө тангараг өргөх ёслолын ажиллагаа явуулах газар, товыг тогтоож, тангараг өргөх хуульчдад мэдэгдэж, тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэлийг хангаж, зохион байгуулна.

[/Энэ зүйлийн нэрийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

2.2 дугаар зүйл.Тангараг өргүүлэх үйл ажиллагааны бэлтгэл хангах

[/Энэ зүйлийн нэрийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

1.Хуульчийн тангараг өргөх ажиллагааг ёслол төгөлдөр зохион байгуулах бөгөөд тангараг өргөх байрны төв хэсэгт Төрийн сүлд, Холбооны бэлгэдлийг, баруун хэсэгт төрийн далбааг хүндэтгэлтэйгээр байрлуулсан байна.

2.Тангараг өргөх байрны баруун гар талд тангараг өргөх гэж буй хуульчдад зориулсан ширээ, сандал, зүүн гар талд ёслолын ажиллагаанд уригдан оролцогчдод зориулсан ширээ, сандал, байрны гол хэсэгт ёслолын ажиллагааг удирдагч үг хэлэх, тангаргийг чээжээр унших хуульчид зориулсан индэрийг тус тус байрлуулсан байна.

3.Тангараг өргөх хуульчдад зориулсан ширээн дээр Монгол Улсын Үндсэн хуулийн хэвлэмэл хувь, Хуульчийн тангаргийн бичиг, гарын үсэг зурах үзэг тавьсан байна.

4.Тангаргийн бичгийн нэг нүүрний дээд хэсэгт Төрийн сүлдийг алтлаг өнгөөр дүрсэлж, шил талд нь "Хуульчийн тангараг" гэсэн үгийг монгол үсгээр, доод хэсэгт кирилл үсгээр тус тус дармалдсан байна. Нөгөө нүүрэнд хуульчийн тангаргийг монгол, кирилл үсгээр гүн хөх өнгөөр гоёмсог хэвлэсэн байна.

5.Тангараг өргөх байрыг шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр тоногосон байна.

6.Хуульчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа нийслэлд явагдаж байгаа бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их хурал, Монгол Улсын Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, гадаадын дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн, тэдний төлөөлөгч, хэвлэл, мэдээллийн ажилтнууд, аймаг, дүүрэгт явагдаж байгаа бол нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, давж заалдах, анхан шатны шүүх, тухайн орон нутаг дахь прокурорын газрын удирдах албан тушаалтан, иргэдийн төлөөлөлийг урьж, оролцуулна.

2.3 дугаар зүйл.Тангараг өргөх ёслолын ажиллагаа

[/Энэ зүйлийн нэрийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

1.Хуульчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг Холбооны Ерөнхийлөгч эсхүл түүний томилсон албан тушаалтан удирдана.

2.Хуульчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан ёслолын ажиллагааг нээж, тангаргийг чээжээр дээдлэн дуудах хуульчийг танилцуулж, индэрт урина.

3.Хуульчийн тангаргийг хамтаар буюу ганцаар өргөж болох бөгөөд хамтаар өргөхөд Холбооны Тамгын газраас томилогдсон хуульч Хуульчийн тангаргийг чээжээр дээдлэн дуудаж, бусад нь дагалдана. Хуульч тангараг өргөж байх үед урилгаар оролцогчид босож хүндэтгэнэ.

4.Тангаргийг чээжээр дээдлэн дуудах хуульч Монгол Улсын Үндсэн хуулийн хэвлэмэл хувь дээр баруун гараа тавиад тангаргийг чээжээр дээдлэн дуудаж дууссаны дараа Төрийн далбааны дэргэд очиж зүүн өвдөг сөгдөн адис авна.

[/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

5.Тангаргийг чээжээр дуудсан хуульч тангаргийн бичигт гарын үсэг зурсны дараа тухайн ёслолын ажиллагаанд оролцож байгаа хуульчид хөтлөгчийн дуудсан дарааллын дагуу Төрийн далбаанаас адис авсаны дараа тангаргийн хуудсанд гарын үсгээ зурж, тангаргийн бичгээ ёслолын ажиллагааг удирдаж буй албан тушаалтанд гардуулан өгнө.

[/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

6.Тангараг өргөх ёслолын ажиллагаанд оролцож байгаа хуульчид тангаргаа өргөж дууссаны дараа ёслолын ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан тангараг өргөсөн хуульчдад баяр хүргэж, Монгол Улсын Төрийн дуулал эгшиглүүлснээр ёслолын ажиллагаа дуусгавар болно.

/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

2.4 дүгээр зүйл. Тангараг өргөх ёслолын ажиллагааг хөтлөгч

1. Холбооны Тамгын газар тангараг өргөх ёслолын ажиллагааг тогтоосон дарааллын дагуу хөтлөх хөтлөгчийг урьж ажиллуулж болно.

2. Хөтлөгч нь Холбооны Тамгын газраас тогтоосон дарааллын дагуу тангараг өргөх ёслолын ажиллагааг хөтлөн явуулна.

/Энэ зүйлийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор нэмсэн/

2.5 дугаар зүйл. Тангараг өргөх ёслолын ажиллагааг баримтжуулах

1. Тангараг өргөх ёслолын ажиллагааг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл ашиглан баримтжуулна.

2.6 дугаар зүйл. Тангаргийн хуудсыг хадгалах

1. Хуульчийн тангаргийн хуудсыг тухайн хуульчийн хувийн хэрэгт хавсарган хадгална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

3.1 дүгээр зүйл. Журам хүчин төгөлдөр болох

1. Энэ журмыг 2013 оны 11 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

/Энэ бүлгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор нэмсэн/